



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/01/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Ч.Удвалноров

Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НА	Нотлох аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймэг, Хэрлэн сум 7-р баг
ЗДП-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.21 № 104

танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.ЭНХЭЭ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020877

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,228,000.00	5,228,000.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,228,000.00	5,228,000.00
354	Хангамжийн материал	5,228,000.00	5,228,000.00
35420	Аж ахуйн материал	3,998,000.00	3,998,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,230,000.00	1,230,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	27,957,072.74	53,041,248.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,957,072.74	53,041,248.05
392	Биет хөрөнгө	27,907,072.86	53,041,248.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	120,000,000.00	32,340,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-120,000,000.00	-898,333.34
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,216,470.67	51,854,470.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,607,449.98	-34,743,318.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,302,958.00	18,952,958.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,004,905.83	-14,464,529.00
393	Биет бус хөрөнгө	49,999.88	00.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,300,000.12	-1,350,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	33,185,072.74	58,269,248.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	33,185,072.74	58,269,248.05
51	Засгийн газрын хувь оролцоо	33,185,072.74	58,269,248.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60,169,756.83	60,169,756.83
51101	Өмч: - төрийн	60,169,756.83	60,169,756.83
512	Хуримтлагдсан үр дүн	-30,407,952.09	-5,323,776.78
51210	Өмнөх үеийн үр дүн	-30,407,952.09	-30,407,952.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	25,084,175.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,423,268.00	3,423,268.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	33,185,072.74	58,269,248.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,025,975,200.00	946,508,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	32,340,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	32,340,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	32,340,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	32,340,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,025,975,200.00	914,168,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,577,900,000.00	413,680,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	900,000.00	5,480,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,577,000,000.00	408,200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	448,075,200.00	500,488,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	448,075,200.00	500,488,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,040,436,008.65	921,424,524.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,040,436,008.65	921,424,524.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,958,319,886.12	900,208,387.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	160,991,523.00	207,757,350.85
210101	Үндсэн цалин	156,632,054.49	201,517,380.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,359,468.51	6,239,970.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,561,154.47	26,969,625.00
210201	Тэтгэврийн даатгал	13,981,587.47	18,667,319.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,644,892.00	2,075,577.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,315,914.00	1,660,460.00
210204	Ажилгүйдлийн даатгал	328,977.00	415,117.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,289,784.00	4,151,152.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,480,000.00	5,110,000.00
210301	Гэрэл, цахилгаан	880,000.00	928,000.00
210302	Түлш, халаалт	1,750,000.00	1,850,000.00
210303	Цэвэр, бохир ус	220,000.00	232,000.00
210304	Байрны түрээс	3,630,000.00	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,832,468.00	16,025,535.00
210401	Бичиг хэрэг	3,499,830.00	1,726,200.00
210402	Тээвэр, шатахуун	15,109,749.00	11,520,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,818,889.00	1,800,000.00
210404	Ном, хэвлэл	886,000.00	479,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	518,000.00	499,835.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,050,000.00	10,282,220.00
210604	Урсгал засвар	4,050,000.00	10,282,220.00
2107	Томилолт, зочны зардал	5,265,000.00	9,553,700.00
210702	Дотоод албан томилолт	5,265,000.00	9,553,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,543,980.00	191,719,009.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,181,980.00	191,458,011.00
210803	Даатгалын үйлчилгээ	140,000.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,000.00	142,748.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,613,595,760.65	432,790,947.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,568,189,952.00	408,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,450,000.00	15,047,123.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,955,808.65	9,543,824.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,116,122.53	21,216,137.15
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	66,000,000.00	10,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	66,000,000.00	10,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,452,300.00	2,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,382,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,070,000.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,663,822.53	9,216,137.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,663,822.53	9,216,137.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-14,460,808.65	25,084,175.31
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-14,460,808.65	25,084,175.31

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,169,756.83	3,742,768.00	26,016,346.71	89,928,871.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,169,756.83	3,742,768.00	26,016,346.71	89,928,871.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	33,687,834.10	33,687,834.10
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,169,756.83	3,423,268.00	-30,407,952.09	33,185,072.74
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,169,756.83	3,423,268.00	-30,407,952.09	33,185,072.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,169,756.83	3,423,268.00	-30,407,952.09	33,185,072.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	25,084,175.31	25,084,175.31
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,169,756.83	3,423,268.00	-5,323,776.78	58,269,248.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,025,975,200.00	914,168,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,025,975,200.00	914,168,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,577,900,000.00	413,680,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	900,000.00	5,480,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,577,000,000.00	408,200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	448,075,200.00	500,488,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	448,075,200.00	500,488,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,025,975,200.00	914,168,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,025,975,200.00	914,168,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,943,859,077.47	892,952,562.85

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	160,991,523.00	207,757,350.85
210101	Үндсэн цалин	156,632,054.49	201,517,380.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,359,468.51	6,239,970.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,561,154.47	26,969,625.00
210201	Тэтгэврийн даатгал	13,981,587.47	18,667,319.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,644,892.00	2,075,577.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,315,914.00	1,660,460.00
210204	Ажилгүйдлийн даатгал	328,977.00	415,117.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,289,784.00	4,151,152.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,480,000.00	5,110,000.00
210301	Гэрэл, цахилгаан	880,000.00	928,000.00
210302	Түлш, халаалт	1,750,000.00	1,850,000.00
210303	Цэвэр, бохир ус	220,000.00	232,000.00
210304	Байрны түрээс	3,630,000.00	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,127,468.00	16,025,535.00
210401	Бичиг хэрэг	3,499,830.00	1,726,200.00
210402	Тээвэр, шатахуун	15,109,749.00	11,520,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,818,889.00	1,800,000.00
210404	Ном, хэвлэл	886,000.00	479,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	813,000.00	499,835.00
2105	Нормативт зардал	1,230,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,230,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,530,000.00	11,932,220.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,600,000.00	00.00
210602	Тавилга	880,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	4,050,000.00	10,432,220.00
2107	Томилолт, зочны зардал	5,265,000.00	9,553,700.00
210702	Дотоод албан томилолт	5,265,000.00	9,553,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,543,980.00	191,719,009.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,181,980.00	191,458,011.00
210803	Даатгалын үйлчилгээ	140,000.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,000.00	142,748.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,590,129,952.00	423,885,123.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,577,679,952.00	408,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,450,000.00	15,685,123.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,116,122.53	21,216,137.15
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	66,000,000.00	10,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	66,000,000.00	10,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,452,300.00	2,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,382,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,070,000.00	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,663,822.53	9,216,137.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,663,822.53	9,216,137.15

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	500,488,700.00	491,272,562.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,488,700.00	491,272,562.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	488,488,700.00	479,272,562.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,360,000.00	207,757,350.85
210101	Үндсэн цалин	203,000,000.00	201,517,380.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,360,000.00	6,239,970.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,688,500.00	26,969,625.00
210201	Тэтгэврийн даатгал	19,194,100.00	18,667,319.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,123,600.00	2,075,577.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,698,400.00	1,660,460.00
210204	Ажилгүйдлийн даатгал	425,200.00	415,117.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,247,200.00	4,151,152.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,110,000.00	5,110,000.00
210301	Гэрэл, цахилгаан	928,000.00	928,000.00
210302	Түлш, халаалт	1,850,000.00	1,850,000.00
210303	Цэвэр, бохир ус	232,000.00	232,000.00
210304	Байрны түрээс	2,100,000.00	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,026,200.00	16,025,535.00
210401	Бичиг хэрэг	1,726,200.00	1,726,200.00
210402	Тээвэр, шатахуун	11,520,000.00	11,520,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,800,000.00
210404	Ном, хэвлэл	480,000.00	479,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	499,835.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,300,000.00	11,932,220.00
210602	Тавилга	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	10,800,000.00	10,432,220.00
2107	Томилолт, зочны зардал	9,600,000.00	9,553,700.00
210702	Дотоод албан томилолт	9,600,000.00	9,553,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,704,000.00	191,719,009.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	191,000,000.00	191,458,011.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	140,000.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	142,748.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,000.00	00.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13700000.00	10205123.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,700,000.00	10,205,123.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12000000.00	12000000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,000,000.00	10,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,000,000.00	10,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	500,488,700.00	491,272,562.85
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	500,488,700.00	491,272,562.85
132001	Орон нутгийн төсвөөс	500,488,700.00	491,272,562.85
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		
620001	Удирдах ажилтан	00.00	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	413,680,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	413,680,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	413,680,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	413,680,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	408,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,480,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	413,680,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	413,680,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,480,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	408,200,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлүүдийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Ч.Удвалноров нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2/10 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хэрэгжүүлэн ажилладаг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 4,040.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 40.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 28.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 5.2 сая төгрөг байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 104.5 сая төгрөг болж 85.4 сая төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 0.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 1.7 сая төгрөгийн тавилга эд хогшил, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 32.3 сая төгрөгийн авто тээврийн хэрэгслээр нэмэгдэж, 120.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,076.5 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онд цагаатгалын нөхөн олговор олгосонтой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 3,119.0 сая төгрөгөөр буурсан нь бараа үйлчилгээний бусад зардал буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 500.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 500.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 500.5 сая төгрөгийн төсөв баталснаас 500.5 сая төгрөгийг улсын төсвөөс бүрэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 491.3 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд бүрэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 98.1 хувь буюу 491.3 сая төгрөг, буцаан төвлөрүүлсэн 1.9 хувь буюу 9.2 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид олгох санхүүжилтээс 408.2 сая төгрөг, төсөл хөтөлбөрөөс 5.5 сая төгрөг нийт 413.7 сая төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дорнод аймгийн ИТХ-ын 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн хугацаанд 147 мэдээллийг бүрэн мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,654.0 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2.5 сая төгрөгийн залруулгийг бүрэн хийж хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар захиргааны хэм хэмжээгээр тогтоосон тогтоол, журмуудыг мөрдөж ажиллаж байгаа эсэхийг анхаарч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 10.0 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант хугацаанд залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

4.3 Албан шаардлага

Төсвийн хөрөнгөөс Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, ... худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" гэж заасныг зөрчин 1.7 сая төгрөгийн албан конторын тавилга худалдан авч, 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" гэж заасны дагуу батлагдсан төсвийн зардлын дүнд 5.4 сая төгрөгийн хэмнэлттэй байхаар удирдан зохион байгуулж ажиллаагүй нийт 7.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд Шилэн дансны сайтад 2 мэдээлэл хуулийн хугацаа хоцроон мэдээлсэн.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заасны дагуу мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд Орон нутгийн ИТХ-д суудалтай намд санхүүгийн дэмжлэг олгох тухай хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байхад аймгийн ИТХ-д суудалтай намуудад 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Орон нутгийн ИТХ-д суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгохгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дорнод аймгийн ИТХ	4	17.1	-	-	-	-	2	7.1	2	10.0